

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2023.07.07

№ 23/09

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, Банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14.10, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 07 -ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Богд Банк” ХК нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн урьдчилсан байдлаарх татварын дараах цэвэр ашиг болох 15,125,296,322.86 төгрөгөөс нэгж хувьцаанд 3.03 төгрөг буюу “Богд Банк” ХК-ийн 1,250,000,000.00 ширхэг хувьцаанд нийт 3,787,500,000.00 төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангасан болохыг дурьдсугай.
3. Компанийн тухай хуулийн 46 зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг энэ тогтоол гарсан өдөр буюу 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөл шийдвэр ирснээс хойш 60 хоногийн дотор хуваарилсугай.
5. Тус тогтоолыг хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Хөрөнгийн биржийн сайтаар 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор мэдэгдсүгэй.
6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилах болохыг дурьдсугай.
7. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэх болохыг дурьдсугай.
8. Тогтоолын хувийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.

9. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
10. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-д үүрэг болгосугай.
11. Ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд танилцуулж тайлагнахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Болдхуяг)-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ